

БАТЛАВ.
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Х.ХЭРЛЭН

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2020-2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Ашигт малтмал, газрын тосны газраас хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт			Хариуцах нэгж албан тушаалтан
			Хугацаа	Хөрөнгө санхүү	Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	
	1	2	3	4	5	6
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр.						
1.	4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох.	2020-2022	Шаардалагүй	Дүгнэлтийг нээлттэй, ил тод болгох ажил хэвшсэн байх.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
2.		Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.	2020-2022		Нөөцийн жагсаалт, бүртгэлийг ил тод, нээлттэй байлгах ажил хэвшсэн байх	

3.	4.1.1.2.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2020-2022	Шаардалаггүй	Шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдсэн байх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
4.	4.1.1.9.Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох.	2020-2022	Шаардалаггүй	Албан бичиг цахим орчинд баталгаажиж, мэдээлэл солилцох мэдээллийн систем бий болсон байх.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
5.	4.1.1.10.Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.	2020-2022	5.000.000 төг	Хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувийг давтан сургасан байх.	ЭБАТ
Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр.						
6.	4.1.6.5.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох.	2020-2022	Шаардалаггүй	Олон нийтийн хяналт сайжирсан байх	Уул уурхайн үйлдвэрлэл технологийн хэлтэс
7.		Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх.	2020 он	Шаардалаггүй	Байгаль орчинг хамгаалах ажлыг хийх, хууль, журмыг мөрдүүлж хэвшүүлсэн байх	Газрын тосны ашиглалтын хэлтэс

Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр.

8.	4.1.7.3.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.	Төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	2020-2022	Шаардалаггүй	Жагсаалтад дурдсан төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлсэн байх.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
----	--	--	-----------	--------------	---	-------------------------------------

Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

9.	4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор аж ахуй нэгжид сурталчилгааны ажлыг зохион байгуулах.	2020-2022	2.000.000 төг	Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх	ЭБАТ
----	--	--	-----------	---------------	--	------

Төлөвлөгөө боловсруулсан:

Дотоод асуудал, нууц хариуцсан ахлах мэргэжилтэн



/Б.Алтан-Очир/